



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/506

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Донорын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цусны аюулгүй байдлын хяналт, үнэлгээ хийх журмыг 1 дүгээр, мөшгөн тогтооход шаардлагатай мэдээллийг 2 дугаар, урвал, гарах шахсан тохиолдол, үл тохирлыг бүртгэх маягтыг 3 дугаар, урвал мэдээлэх маягтыг 4 дүгээр, ноцтой хүндрэлийг мэдээлэх маягтыг 5 дугаар, урвал, ноцтой хүндрэлийн шалтгааны түвшинг 6 дугаар, ноцтой хүндрэлийг мэдээлэх жилийн тайлангийн маягтыг 7 дугаар, цусны донорт илэрсэн сөрөг урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх маягтыг 8 дугаар, цусны донорт илэрсэн урвал, хүндрэлийн тайлангийн маягтыг 9 дүгээр, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх урсгалыг 10 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/, Цус сэлбэлт судлалын үндэсний төв /Н.Эрдэнэбаяр/-д, журмыг хэрэгжүүлж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, ерөнхий захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 02 дугаар тушаалын 7 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
12 дугаар сарын 07 өдрийн 4506 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



Цусны аюулгүй байдлын хяналт, үнэлгээ хийх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь цус, сийвэн, эс цуглуулах, үйлдвэрлэх, шинжлэх, цус сэлбэхтэй холбоотой гарах шахсан тохиолдол, үл тохирол, алдаа, сөрөг урвал, хүндрэл, ноцтой тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, шалтгааныг мөшгөн тогтоох, алдааг засах, урьдчилан сэргийлэх зорилготой.

1.2. Энэхүү журмаар цусны донор, цус сэлбүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, донороос цус цуглуулахаас эхлэн үйлчлүүлэгчид цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэн үр дүнг үнэлэх бүх үе шатыг тогтмол хянаж, үйл ажиллагааг байнга сайжруулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.3. Энэ журам нь эрсдлийн удирдлагыг сайжруулах, мэдээллийн нууцлалыг хадгалах, буруутган шийтгэхгүй байх, итгэл үнэмшил төрүүлэх зарчмыг баримтална.

1.4. Энэхүү журмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнууд, эмнэлгийн мэргэжилтэн мөрдөн ажиллана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг:

2.1.1. Цусны аюулгүй байдлын хяналт, үнэлгээ хийх журмыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.1.2 Цусны аюулгүй байдлыг хангах бодлого, зааврыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.3 Цусны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны санхүүжилтыг шийдвэрлэх;

2.1.4 Тушаалыг 3 жил тутам хянаж, шинэчлэн сайжруулах.

2.2. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн эрх, үүрэг:

2.2.1. Цусны аюулгүй байдлын хяналт, үнэлгээ хийх журмыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах;

2.2.2. Цусны донорын бүртгэл, цус, сийвэн, эс цуглуулах, үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, ханган нийлүүлэх үйл ажиллагааг тогтмол хянах, баримтжуулах, үл тохирол, алдааг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, шалтгааныг мөшгөн тогтоох, засах, сэргийлэх, хянах, үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.2.3. Эмнэлгүүдээс цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой гарсан үл тохирол, алдаа, урвал, хүндрэл, ноцтой тохиолдлын мэдээллийг хүлээн авах,

бүртгэх, хүндрэл, ноцтой тохиолдлын шалтгааныг мөшгөн тогтооход оролцох, мэргэжлийн түвшинд хэлэлцэж, зөвлөмж хүргүүлэх, хяналт, үнэлгээг хийх, эргэн мэдээлэх, баримтжуулах, улсын хэмжээний мэдээллийг цуглуулж, нэгтгэн тайланг Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-д илгээх;

- 2.2.4. Цусны донор, эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах;
- 2.2.5. Эмнэлэг, олон улсын байгууллагатай цусны аюулгүй байдлын хяналт, үнэлгээний талаар хамтран ажиллах.

2.3. Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн эрх, үүрэг:

- 2.3.1. Орон нутгийн хэмжээнд цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах;
- 2.3.2. Цус сэлбэлтэд оролцдог эмч, мэргэжилтэн бүр цус сэлбэлтийн үе шат бүрийг байнга хянаж, сөрөг урвал, хүндрэлийг илрүүлж, мэдээлэн, яаралтай тусламж үзүүлэн засах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.3.3. Цусны донорын бүртгэл, цус, сийвэн, эс цуглуулах, үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, ханган нийлүүлэх үйл ажиллагааг тогтмол хянаж, баримтжуулах, үл тохирол, алдааг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, шалтгааныг мөшгөн тогтоох, засах, сэргийлэх, хяналт, үнэлгээг хийх;
- 2.3.4. Цус сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах;
- 3.3.1 Үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулж, нэгтгэн тайланг Цус сэлбэлт судлалын үндэсний төв (ЦССҮТ), Эрүүл мэндийн газар (ЭМГ), Цусны салбар төвд илгээх.

2.4. Цусны салбар төвийн эрх, үүрэг:

- 2.4.1. Цус, сийвэн, эс цуглуулах үйл ажиллагааг байнга хянаж, сөрөг урвал, хүндрэлийг илрүүлэх, мэдээлэх, яаралтай тусламж үзүүлэх, засах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.4.2. Орон нутгийн хэмжээнд цусны донорын бүртгэл, цус, сийвэн, эс цуглуулах, үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах, ханган нийлүүлэх, тээвэрлэх үйл ажиллагааг тогтмол хянаж, үл тохирол, алдааг бүртгэж, ЦССҮТ-д мэдээлэх;
- 2.4.3. Эмнэлгийн тасаг нэгжид цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой гарах шахсан тохиолдол, үл тохирол, алдаа, сөрөг урвал хүндрэл, ноцтой тохиолдлын мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хүндрэл, ноцтой тохиолдлын шалтгааныг мөшгөн тогтооход оролцох, зөвлөмж хүргүүлэх, хяналт, үнэлгээг хийх, эргэн мэдээлэх, баримтжуулах, мэдээллийг цуглуулах, тайланг нэгтгэн ЦССҮТ-д илгээх;
- 2.4.4. Цусны донор, эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах;
- 2.4.5. ЭМГ, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвтэй цусны аюулгүй байдлын хяналт, үнэлгээний талаар хамтран ажиллах.

2.5. Төр ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг:

- 2.5.1. Цус, цусан бүтээгдэхүүнийг захиалах, хүлээн авах, сонгох, хадгалах, тээвэрлэх, сэлбэхтэй холбоотой бүх үйл ажиллагааг хянаж, баримтжуулах, гарах шахсан тохиолдол, үл тохирол, алдаа, сөрөг урвал, хүндрэл, ноцтой тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, шалтгааныг мөшгөн тогтоох тогтолцоог бүрдүүлэх;
- 2.5.2. Үл тохирол, алдаа гарах шахсан тохиолдол, үл тохирол, алдаа, сөрөг урвал, хүндрэл, ноцтой тохиолдлын шалтгааныг шуурхай арилгаж, засах, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах;
- 2.5.3. Цус сэлбүүлэгч өвчтөн, эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хадгалах;
- 2.5.4. Гарах шахсан тохиолдол, үл тохирол, алдаа, сөрөг урвал, хүндрэл, ноцтой тохиолдлыг ЦССҮТ, Цусны салбар төв, Эмнэлгийн цусны нөөц зохицуулах нэгжид мэдээлэх.

Гурав. Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлтийн аюулгүй байдлын хяналт, үнэлгээ

3.1. Цус сэлбэлт хийж байгаа эмч, мэргэжилтний үүрэг:

- 3.1.1. Цус, цусан бүтээгдэхүүн захиалах, хадгалах, тээвэрлэх, сонгох, сэлбэх, үр дүнг үнэлэх бүх үе шатыг хянаж, гарах шахсан тохиолдол, үл тохирол, сөрөг урвал, хүндрэл, ноцтой тохиолдлыг илрүүлж, Урвал, гарах шахсан тохиолдол, үл тохирол, ноцтой хүндрэлийг бүртгэх маягтын дагуу бүрэн бүртгэх;
- 3.1.2. Урвал, хүндрэл илэрсэн үед яаралтай тусламж үзүүлэх, шалтгааныг мөшгөн тогтоох, засах арга хэмжээг шуурхай авах, баримтжуулах;
- 3.1.3. Бүртгэл, авсан арга хэмжээний мэдээллийг орон нутагт бол Цусны салбар төвд, Улаанбаатар хотод бол эмнэлгийн Цусны нөөц зохицуулах нэгжид мэдээлэх;
- 3.1.4. Урвал, хүндрэл, алдаа, эрсдэл гарахаас сэргийлж ажиллах.

3.2. Цусны салбар төв, эмнэлгийн цусны нөөц зохицуулах нэгжийн үүрэг:

- 3.2.1. Цус сэлбэх үйл ажиллагаанд илэрсэн сөрөг урвал, гарах шахсан тохиолдол, үл тохирол, ноцтой тохиолдлыг нэгтгэх ба гарах шахсан тохиолдол, үл тохирлыг байгууллагын хүрээнд мэдээлэн, засч, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангах;
- 3.2.2. Урвал, хүндрэлийн тайланг маягтуудын дагуу сар бүр ЦССҮТ-д мэдээлэх;
- 3.2.3. Хүндрэл, ноцтой тохиолдлыг тухай бүр Ноцтой хүндрэлийг мэдээлэх маягтын дагуу ЦССҮТ-д мэдээлэх ба жилийн тайланг Ноцтой хүндрэлийг мэдээлэх жилийн тайлангийн маягтаар гаргаж, ЦССҮТ-д илгээх;
- 3.2.4. Урвал, хүндрэл алдаа, эрсдэл гарахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.3. Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн үүрэг:

- 3.3.1. Цус сэлбэлттэй холбоотой урвал, хүндрэлийн шалтгааныг мөшгөн тогтоох, засах арга хэмжээг зохион байгуулах, баримтжуулах;
- 3.3.2. Цус сэлбэлттэй холбоотой сөрөг урвал, хүндрэл, үл тохирол, гарах шахсан тохиолдол, ноцтой тохиолдлыг давтагдахаас сэргийлэх цогц арга хэмжээг зохион байгуулах, баримтжуулах;
- 3.3.3. Цус сэлбэлтэд оролцдог эмнэлгийн мэргэжилтэнд цусны аюулгүй байдлыг хангах чиглэлээр тасралтгүй сургалтыг зохион байгуулж, үр дүнг үнэлж ажиллах;

3.3.4. Цусны аюулгүй байдал, хяналт, үнэлгээний талаар хэрэгжүүлсэн ажлын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор ЦССҮТ-д хүргүүлж, баримтжуулах.

3.4. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлагын үүрэг:

- 3.4.1. Цус захиалах, сонгох, сэлбэхтэй холбоотой гарах шахсан тохиолдол, үл тохирол, сөрөг урвал, алдаа, ноцтой хүндрэл, тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, мөшгөн тогтоох, засах, сэргийлэх арга хэмжээг авах, баримтжуулах;
- 3.4.2. Цус, цусан бүтээгдэхүүн захиалах, тээвэрлэх, хадгалах, сонгох, сэлбэх үйл ажиллагаа зөв явагдах нөхцөлийг бүрдүүлэх, алдаа гарах, эрсдэлээс сэргийлэх зорилгоор стандарт, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, хүний нөөцийг сургах, чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах.

Дөрөв. Цусны донорын аюулгүй байдлын хяналт, үнэлгээ

4.1. Цус, цусны бүрэлдэхүүн цуглуулах эмнэлгийн мэргэжилтний үүрэг:


- 4.1.1. Донороос цус, сийвэн, эс цуглуулах үйл ажиллагааны шат дамжлага бүрийг байнга хянах, гарах шахсан тохиолдол, үл тохирол, сөрөг урвал, хүндрэл, алдаа, эрсдэл, ноцтой тохиолдлыг илрүүлэх, донорт илэрсэн сөрөг урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх маягтын дагуу бүртгэж, мэдээлэх;
- 4.1.2. Урвал, хүндрэл илэрсэн үед яаралтай тусламж үзүүлэх, шалтгааныг мөшгөн тогтоож, засах арга хэмжээг шуурхай авах, баримтжуулах;
- 4.1.3. Урвал, хүндрэл, авсан арга хэмжээний мэдээллийг Цусны салбар төвийн эрхлэгч, ЦССҮТ-ийн Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгчид мэдээлэх;
- 4.1.4. Урвал, хүндрэл, алдаа, эрсдэл гарахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

4.2. Цусны салбар төв, алба, тасгуудын үүрэг:

- 4.2.1. Донороос цус, сийвэн, эс цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, эмнэлгээс захиалга авч бүтээгдэхүүн нийлүүлэх бүх үе шатыг тогтмол хянаж, үйл ажиллагааг байнга сайжруулан, тасралтгүй хөгжүүлэх;
- 4.2.2. Цус, сийвэн, эс цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, эмнэлгээс захиалга авч бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбоотой илэрсэн сөрөг урвал, хүндрэл, гарах шахсан тохиолдол, ноцтой тохиолдлыг давтагдахаас сэргийлэх цогц арга хэмжээг зохион байгуулж, баримтжуулах;
- 4.2.3. Цус, сийвэн, эс цуглуулах үйл ажиллагааны явцад илэрсэн сөрөг урвал, ноцтой тохиолдлын мэдээллийг нэгтгэн, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг Донорт илэрсэн сөрөг урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх маягтын дагуу сар бүр ЦССҮТ-д мэдээлэх;
- 4.2.4. Хүндрэл, ноцтой тохиолдлыг тухай бүр цусны донорт илэрсэн урвал хүндрэлийн мэдээ, тайлангийн маягтын дагуу ЦССҮТ-д мэдээлэх;
- 4.2.5. Урвал, хүндрэл, алдаа, эрсдэл гарахаас сэргийлж ажиллах;
- 4.2.6. Цусны донор, цусны аюулгүй байдлыг хангахад мөрдөх стандарт ажиллагааны зааврыг боловсруулах, хэрэгжүүлэх, тогтмол хянаж, шинэчлэн сайжруулах, эмч мэргэжилтэнг сургах;
- 4.2.7. Донорт яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлыг хангаж, шаардлагатай эм, хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, эмнэлгийн мэргэжилтэнг сургаж, ур чадвар эзэмшүүлэх.

4.3. Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь:

- 4.3.1. Донороос цус, сийвэн, эс цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, эмнэлгээс захиалга авч бүтээгдэхүүн нийлүүлэх бүх үе шатыг тогтмол хянаж, үйл ажиллагааг байнга сайжруулан, тасралтгүй хөгжүүлэх;
- 4.3.2. Цус, сийвэн, эс цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, эмнэлгээс захиалга авч бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаанд илэрсэн гарах шахсан тохиолдол, сөрөг урвал хүндрэл, алдаа, эрсдэл, ноцтой тохиолдлыг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэх;
- 4.3.3. Тайлан мэдээг ЭМЯ, ЭМХТ, ДЭМБ-д илгээх, олон улсын мэдээллийн сүлжээнд мэдээлэл солилцох;
- 4.3.4. Цусны донор, цусны аюулгүй байдлыг хангах стандарт ажиллагааны зааврыг баталгаажуулах, баримт бичгийн хяналт хийх;
- 4.3.5. Цусны албаны үйл ажиллагааг хэвийн аюулгүй явагдах нөөцийг бүрдүүлж, удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.



Мөшгөн тогтооход шаардлагатай мэдээлэл

А– Эмнэлгийн байгууллага:

Цус, цусан бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч байгууллага.....

1. Хүлээн авсан цус, цусан бүтээгдэхүүний мэдээлэл (бүтээгдэхүүний нэр, төрөл, цусны ABO, резус бүлэг, цуврал, савлалтын дугаар, хүүдийний гуурсны дугаар, хүлээн авсанон, сар, өдөр, цаг, минут);
2. Сэлбэсэн цус, цусан бүтээгдэхүүний мэдээлэл (бүтээгдэхүүний нэр, төрөл, цусны ABO, резус бүлэг, цуврал, савлалтын дугаар, хүүдийний гуурсны дугаар, сэлбэлт хийсэн он, сар, өдөр, цаг, минут);
3. Цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлсэн өвчтөний мэдээлэл (өвчтөний овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, цусны ABO, резус бүлэг, сэлбэлт хийсэн заалт, он, сар, өдөр, цаг, минут, илэрсэн шинж тэмдэг);
4. Цус цусан бүтээгдэхүүн захиалах, сонгох, сэлбэхтэй холбоотой илэрсэн гарах шахсан тохиолдол, үл тохирол, алдаа, сөрөг урвал, хүндрэл, ноцтой тохиолдлын тоо, шалтгааныг тодруулсан дүн, хэрэгжүүлсэн засах, сэргийлэх арга хэмжээ;
5. Эмчилгээнд хэрэглээгүй цус, цусан бүтээгдэхүүний мэдээлэл (бүтээгдэхүүний нэр, төрөл, цусны ABO, резус бүлэг, цуврал, савлалтын дугаар, хэрэглээгүй шалтгаан, устгасан он, сар өдөр).


Б – Цусны алба, эмнэлгийн цусны нөөц зохицуулах нэгж:

Цусны алба:

Цусны нөөц зохицуулах нэгжийн нэр:

1. Донорыг танин тодруулах мэдээлэл (ургийн овог, овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, донорын төрөл, цусны ABO, резус бүлэг, цус өгөлтийн код, дугаар);
2. Цусан бүтээгдэхүүнийг танин тодруулах мэдээлэл (бүтээгдэхүүний нэр, төрөл, цусны ABO, резус бүлэг, цуврал, савлалтын дугаар, хүүдийний гуурсны дугаар);
3. Цус, цусан бүтээгдэхүүн цуглуулсан, шинжилсэн, үйлдвэрлэсэн, хорионд хадгалсан, хорионоос чөлөөлсөн, нөөцөнд шилжүүлсэн, хадгалсан он, сар, өдөр, цаг, минут;
4. Эмнэлгээс захиалга хүлээн авсан мэдээлэл (сэлбүүлэх өвчтний овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, цусны ABO, резус бүлэг; бүтээгдэхүүний нэр, төрөл, цусны ABO, резус бүлэг, цуврал, савлалтын дугаар, захиалга хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут);
6. Эмнэлэгт олгосон цус, цусан бүтээгдэхүүний мэдээлэл (бүтээгдэхүүний нэр, төрөл, цусны ABO, резус бүлэг, цуврал, савлалтын дугаар, хүүдийний гуурсны дугаар, хүлээлгэн өгсөн он, сар, өдөр, цаг, минут);
7. Устгасан цус, цусан бүтээгдэхүүний мэдээлэл (бүтээгдэхүүний нэр, төрөл, цусны ABO, резус бүлэг, цуврал, савлалтын дугаар, хүүдийний гуурсны дугаар, устгасан он, сар, өдөр, цаг, минут);

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
12 дугаар сарын 17 өдрийн 11 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт



Урвал, гарах шахсан тохиолдол, үл тохирлыг бүртгэх маягт

Байгууллагын нэр:.....
Тасгийн нэр:.....
Эмч, мэргэжилтний (доогуур нь зурах) овог нэр.....
Огноо (он/сар/өдөр):
Сэлбэсэн бүтээгдэхүүн: Улаан эсийн бүтээгдэхүүн
Сийвэнгийн бүтээгдэхүүн
Эсийн бүтээгдэхүүн
Урвалын хэлбэр
Үл тохирол, алдаа гарах шахсан тохиолдол
Үл тохирол
Бүртгэсэн огноо (он/сар/өдөр):.....

Тайлбар: Энэ маягтыг сөрөг урвал, гарах шахсан тохиолдол, үл тохирлыг илрүүлсэн эмч, мэргэжилтэн бөглөнө.

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
12 дугаар сарын 27 өдрийн 11 дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт



Урвал мэдээлэх маягт

Байгууллагын нэр:
.....

Тайлангийн хугацаа:

Урвал, хүндрэлийн төрөл	Бүтээгдэхүүний нэр		
	Урвал, хүндрэлийн тоо		
	Улаан эсийн бүтээгдэхүүн	Сийвэнгийн бүтээгдэхүүн	Эсийн бүтээгдэхүүн
Харшлын тууралт			
Халууралт			
Цусны бүлэг, резус үл тохирлоос шалтгаалсан дархлалын гаралтай цус задрал			
Өөсөө эсрэг бие үүссэнтэй холбоотой дархлалын бус цус задрал			
Дархлалын бус цус задрал			
Сэлбэлттэй холбоотой үүссэн нянгийн халдвар			
Анафилакси/ Хэт мэдрэгжилт			
Цус сэлбэлтээс үүдсэн уушгины гэмтэл			
Цус сэлбэлтээр дамжсан В гепатит вирүсийн халдвар (HBV)			
Цус сэлбэлтээр дамжсан С гепатит вирүсийн халдвар (HCV)			
Цус сэлбэлтээр дамжсан ХДХВ-ийн халдвар (HIV-1/2)			
Цус сэлбэлтээр дамжсан тэмбүүгийн халдвар			
Цус сэлбэлтээр дамжсан бусад вирүсийн халдвар (тодорхой нэрлэж бичих)			
Цус сэлбэлтээр дамжсан бусад паразитын халдвар (тодорхой нэрлэж бичих)			
Цус сэлбэлтийн дараах цусархаг			

тууралт			
Сэлбэсэн эс, эзэн биеийн эсрэг урвал (GVHD)			

Тайлбар:

- *Илэрсэн урвал, хүндрэлийн тоог бүтээгдэхүүний нэр, төрлөөр нэгтгэн гаргаж мэдээлнэ.*
- *Цусны нөөц зохицуулах нэгж, цусны салбар төвийн эмч ЦССҮТ-д сар бүр мэдээлнэ.*

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
12...дугаар сарын 17 өдрийн 11/26 дугаар
тушаалын 5 дугаар хавсралт




Ноцтой хүндрэлийг мэдээлэх маягт

Байгууллагын нэр:.....
Эмч, мэргэжилтний (доогуур нь зурах) овог нэр.....
Огноо (он/сар/өдөр/цаг/минут):
Сэлбэлт хийсэн (он/сар/өдөр/цаг/минут):
Сэлбэлт хийлгэсэн өвчтөний нас..... хүйс.....
Ноцтой хүндрэл өгсөн огноо (он/сар/өдөр/цаг/минут):
Сэлбэсэн бүтээгдэхүүн: Улаан эсийн бүтээгдэхүүн
Сийвэнгийн бүтээгдэхүүн
Эсийн бүтээгдэхүүн
<ul style="list-style-type: none">- Цусны бүлэг, резус үл тохирлоос шалтгаалсан дархлалын гаралтай цус задрал- Өөсөө эсрэг бие үүссэнтэй холбоотой дархлалын бус цус задрал- Дархлалын бус цус задрал- Сэлбэлттэй холбоотой үүссэн нянгийн халдвар- Анафилакси/ Хэт мэдрэгжилт- Цус сэлбэлтээс үүдсэн уушгины гэмтэл- Цус сэлбэлтээр дамжсан В гепатит вирусийн халдвар (HBV)- Цус сэлбэлтээр дамжсан С гепатит вирусийн халдвар (HCV)- Цус сэлбэлтээр дамжсан ХДХВ вирусийн халдвар (HIV-1/2)- Цус сэлбэлтээр дамжсан тэмбүүгийн халдвар- Цус сэлбэлтээр дамжсан бусад вирусийн халдвар (тодорхой нэрлэж бичих)- Цус сэлбэлтээр дамжсан бусад халдвар (тодорхой нэрлэж бичих)- Цус сэлбэлтийн дараах цусархаг тууралт- Сэлбэсэн эс, эзэн биеийн эсрэг урвал (GVHD)

Тайлбар: Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлт хийсэн эмнэлгийн мэргэжилтэн бөглөж,
Цусны салбар төв, ЦССҮТ-д тухай бүр мэдээлнэ.


Эрүүл мэндийн сайдын 2018 оны
12...дугаар сарын 07 өдрийн А/дугаар
тушаалын 6 дугаар хавсралт



Урвал, ноцтой хүндрэлийн шалтгааны түвшин

Болзошгүй шалтгааны түвшин (imputability level)		Тайлбар
Тодорхойлох боломжгүй	ТБ	Шалтгааны зэрэглэлийг мөшгөн тогтоох мэдээлэл хангалтгүй
Холбоогүй	0	Сөрөг урвал, хүндрэл сэлбэлттэй холбоогүй, бусад шалтгааны улмаас үүссэнийг нотолсон
Эргэлзээтэй		Сөрөг урвал, хүндрэл сэлбэлттэй холбоогүйгээр бусад шалтгаанаас үүссэн байх магадлалтай
Байх магадлалтай	1	Сөрөг урвал нь сэлбэлттэй холбоотой байх магадлалтай
Магадлалтай	2	Сөрөг урвал нь сэлбэлттэй холбоотой байх өндөр магадлалтай
Шууд холбоотой	3	Илэрсэн урвал нь сэлбэлттэй холбоотой үүссэнийг нотолсон

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
 12 дугаар сарын 17 өдрийн 11/06 дугаар
 тушаалын 7 дугаар хавсралт



Ноцтой хүндрэлийг мэдээлэх жилийн тайлангийн маягт

Байгууллагын нэр:

Тайлангийн хугацаа:

Цус, цусан бүтээгдэхүүний нэр	Олгосон нэгжийн тоо (Олгосон нийт бүтээгдэхүүний тоо, нэгж)	Сэлбэлт хийгдсэн өвчтөний тоо (Сэлбэлт хийгдсэн нийт өвчтөний тоог олгосон бүтээгдэхүүнээр гаргах)	Сэлбэлт хийсэн ЦЦБ нэгжийн тоо (ЦЦБ –ий нэгжийн тоог бүтээгдэхүүн бүрээр гаргах)	Тайлангийн хугацаанд хийгдсэн сэлбэлтийн тоо	Мэдээл эгдсэн нийт тоо	Нас барсан өвчтөний тоо
Бүхэл цус						
Улаан эсийн бүтээгдэхүүн						
Ялтаст эс						
Сийвэн						
Бусад						
Ноцтой хүндрэлийн тоо, түвшинг цус, цусан бүтээгдэхүүн тус бүрээр гаргах						
Цус, цусан бүтээгдэхүүний нэр:.....		Болзошгүй шалтгааныг тогтоож, баталгаажуулсан ноцтой хүндрэлийн тоо				
		Тодорхойлох боломжгүй	Түвшин 0	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Дархлалын гаралтай цус задрах	АВО бүлгийн үл тохирол	Нийт				
		Нас барсан				
	Өөсөө эсрэг биеийн үл тохирол	Нийт				
		Нас барсан				
Дархлалын бус цус задрал		Нийт				
		Нас барсан				
Цус сэлбэлтээр дамжсан нянгийн халдвар		Нийт				
		Нас барсан				
Анафилакси/ Хэт мэдрэгжилт		Нийт				
		Нас барсан				

Цус сэлбэлттэй холбоотой үүссэн уушгины цочмог гэмтэл		Нийт						
		Нас барсан						
Цус сэлбэлтээр дамжсан вирусийн халдвар	Гепатит В	Нийт						
		Нас барсан						
	Гепатит С	Нийт						
		Нас барсан						
	ХДХВ – ийн халдвар (HIV-1/2)	Нийт						
		Нас барсан						
Бусад (тодорхой бичих)	Нийт							
	Нас барсан							
Цус сэлбэлтээр дамжсан паразитийн халдвар		Нийт						
		Нас барсан						
Цус сэлбэлтийн дараах цусархаг тууралт		Нийт						
		Нас барсан						
Сэлбэсэн эс, эзэн биеийн эсрэг урвал		Нийт						
		Нас барсан						
Цус сэлбэлттэй холбоотой бусад ноцтой урвалууд (тодорхой нэрлэж бичих)		Нийт						
		Нас барсан						

12... дугаар сарын 17 өдрийн 1/506 дугаар тушаалын 8 дугаар хавсралт



Цусны донорт илэрсэн сөрөг урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх маягт

Тасаг нэгжийн нэр _____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ минут _____
 Сөрөг урвал хүндрэл илэрсэн донорын код _____ төрөл _____ нас / хүйс _____
 Тухайн донорт үйлчилж байсан эмч, сувилагч, бусад (зур) _____
 Сөрөг урвал, хүндрэлийг мэдээлсэн хүний нэр.....

Цус өгөлтийн дараах сөрөг урвалын төрөл		Сөрөг урвалын хүндрэлийн зэрэг			
Ерөнхий урвал		хөнгөн	дунд	хүнд	ноцтой
Вазовагал урвал					
Хэсэг газрын урвал	Цусан хураа				
	Судасны гэмтэл /артери, вен/				
	Мэдрэлийн гэмтэл				
	Хожуу цус гадгашлах				
Аферезтэй холбоотой өвөрмөц урвал	Харшлын урвал				
	Анафилакси				
	Цус задрал				
	Эмболи				
	Цитратын урвал				
Бүлэн					
Бусад					

Цус өгөлтийн төрөл бүхэл цус аферез (ялтас эс, сийвэн, улаан эс)
 Байршил цус цуглуулах цэгт цус цуглуулах цэгээс гадна
 Авсан арга хэмжээний бүртгэл

1. Урвал хүндрэлийн төрөл:

1.1 Товч дүрслэл

1.2 Авсан арга хэмжээ , үр дүн: (тухайн үед авсан шуурхай арга хэмжээ, түүний үр дүн, донортой холбогдсон байдал, хожмын уршиг эрсдэл байгаа эсэх)

1.3 Нөлөөлсөн хүчин зүйлс (урвал хүндрэл гарахад нөлөөлсөн хүчин зүйлс)

1.4 Урьдчилан сэргийлэх (үүнээс хэрхэн урьдчилан сэргийлж болох байсан эсэх)


1.5 Магадласан их эмч _____

1.6 Хянасан ажилтан :

1. Тасгийн эрхлэгч _____

2. Чанарын алба _____

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
 12... дугаар сарын 07 өдрийн 12... дугаар
 тушаалын 9 дүгээр хавсралт



Цусны донорт илэрсэн урвал, хүндрэлийн тайлангийн маягт

(Сар, жил)

Байгууллагын нэр					
Тайлангийн хугацаа					
Цуглуулсан цусны хэмжээ (нэгжээр)					
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ (нэгж)					
Эмнэлэгт олгосон бүтээгдэхүүний хэмжээ (нэгж)					
Акталсан бүтээгдэхүүний хэмжээ (нэгж)					
Донорт илэрсэн урвал хүндрэлийн төрөл	Урвал хүндрэлийн зэрэг				
	Хөнгөн	Дунд	Хүнд	Ноцтой	Нийт
Ухаан балартах					
Нийт тохиолдол					
100 000-д ногдох хэмжээ					
Цусан хураа					
Нийт тохиолдол					
100 000-д ногдох хэмжээ					
Судасны гэмтэл артер / вен					
Нийт тохиолдол					
100 000-д ногдох хэмжээ					
Мэдрэлийн судас гэмтэх					
Нийт тохиолдол					
100 000-д ногдох хэмжээ					
Аферезтэй холбоотой хүндрэл					
Нийт тохиолдол					
100 000-д ногдох хэмжээ					
<input type="checkbox"/> харшлын урвал					
<input type="checkbox"/> хэт мэдрэгшилт					
<input type="checkbox"/> цус задрал					
<input type="checkbox"/> эмболи					
<input type="checkbox"/> даралт унах					
<input type="checkbox"/> бүлэн					
<input type="checkbox"/> цитратын урвал					

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
12... дугаар сарын... өдрийн... дугаар
тушаалын 10 дугаар хавсралт



Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх урсгал

